



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/237

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "а", 29.2, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 23/01 дүгээр, 02/22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн хэмжээнд "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 1 дүгээр, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг нийслэлийн 2018 оны төсөвт тусгасан Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, явц, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

111020001413

Нийслэлийн Засаг даргын 2018 оны
 03 дугаар сарын 23-ны өдрийн
 А/233/уу/ захирамжийн нэгдүгээр
 хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
 ХЭРЭГЖҮҮЛЭХ 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

<p>ЗОРИЛГО</p>	<p>Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд оршино.</p>
<p>ҮР НӨЛӨӨ (ҮР НӨЛӨӨНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ)</p>	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэг дэх үе шат /2016-2019/ Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх; Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн байх; Шударга ёсны үзэл санаа нийгэмд төлөвшиж, иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлдэг байх нийгмийн сэтгэлгээ, хандлага өөрчлөгдсөн байх; Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ сайжирсан байх; Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоёр дахь үе шат /2020-2023/ Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ өмнөх үзүүлэлтээс өссөн байх; Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал хангагдсан байх; Авлигад илүү өртсөн салбаруудын болон өндөр түвшний авлигын гэмт хэрэг, зөрчил, гарах шалтгаан нөхцөлийг бууруулсан байх; Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналт сайжирсан байх; Төрийн байгууллагад итгэх иргэний итгэл нэмэгдсэн байх.</p>
<p>1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ</p>	<p>Шударга хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх; Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх; Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх; Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх; Хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;</p>

		Иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачилга, оролцоог дэмжих; Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх; Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх;				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Хэрэгжих хугацаа
Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд: Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:						
1	Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	Төрийн албаны төв зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ-ийг холбогдох байгууллагаар хянуулсны дараа албан тушаалд томилох	Төрийн жинхэнэ албан тушаалд томилох үйл ажиллагаа хуулийн хүрээнд зохион байгуулах	ТАЗ-ийн Нийслэл дэх салбар зөвлөл	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2016-2022
2	Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан, мерит зарчмыг баримтлан томилон, дэвшүүлэх	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага ур чадварын шаардлагыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх	Ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур, ур чадварыг үндэслэн, төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоо бүрдүүлэх	ТАЗ-ийн нийслэл дэх салбар зөвлөл	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2016-2022
3	Олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, төрийн албан хаагчдын үр дүнг "Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт" /KPI/ -ээр үнэлж, хүний нөөцийн бүртгэл	Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл үнэлгээний журам батлагдан, үнэлгээний	НЗДТГ	НМТГ	2016-2019

	арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох, эрх зүйн зохицуулалтыг бий болгох	хяналт, удирдлагын нэгдсэн санг бий болгох	системийн өргөтгөлийг хийх			
4	Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг олон эх үүсвэрээр хүлээн авч хянан шийдвэрлэх, мэдээллийн нэгдсэн санг үүсгэх	Өргөдөл гомдлыг хянах ёс зүйн хорооны үйл ажиллагаа сайжирч, ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтнуудын зөрчлийн мэдээллийг нээлттэй болгох	НЗДТГ	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2016-2019
5	Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	Төрийн албан хаагчдад зориулсан богино хугацааны болон давтан сургалтуудыг зохион байгуулах Авлигын эсрэг боловсрол олгох хөтөлбөрийг боловсруулах ЭБАТ-ыг мэдээлэл арга зүйгээр ханган ажиллах, сургах давтан сургах Нийслэлийн нутгийн захиргааны 50 байгууллагаас хуулийн үйлчлэлд хамаарах мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг гаргуулан авах, хяналт тавих	Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, хөтөлбөрийг боловсруулах	НЗДТГ	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, Олон улсын байгууллага	2016-2019

		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын мэдүүлэг гаргагч албан тушаалтны 2017 оны шинэчилсэн мэдүүлгийг бүртгэх, тайланг нэгтгэх	Мэдүүлгийг бүртгэн, тайланг АТГ-д хүргүүлэх	НЗДТГ	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2016-2019
6	Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуй нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтыг тогтолцоог, боловсронгуй болгох	Авлигын эсрэг хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудас, дүрст сурталчилгаа хийх	Үйл ажиллагаанд ашиглагдах боломжоор хангах	НЗДТГ	-	2016-2019
Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд: Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх						
7	Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлж байгаа үйлчилгээний лавлагаа, мэдээллийг сайжруулах	Лавлагаа, мэдээлэл авах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх	НЗДТГ	НМТГ	2017-2022
8	Төрийн үйлчилгээг иргэдэд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээг бэхжүүлэх	Тусгай зөвшөөрөл олгох нэгдсэн цахим системийг бий болгох	Тусгай зөвшөөрөл олгох, тендерийн үйл ажиллагааг цахимаар үзүүлдэг болох	НЗДТГ, УБЗАА, НМТГ, НХААГ,НГА	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, дүүргүүдийн газрын алба	2017-2022
9		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас зохион байгуулж буй худалдан авах үйл ажиллагааны 70 орчим				

		хувийг цахим хэлбэрт шилжүүлэх			
10		Газрын төлбөрийн тайлан, бүртгэлийг боловсронгуй болгох, гүйцэтгэлийг хянах, мэдээллийн нэгдсэн системд холбох зорилгоор LandPay төлбөрийн цахим програмыг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх, газрын кадастрын Ланд менежер програм хангамжийг нэвтрүүлэх	Газрын төлбөрийн тайлан бүртгэлийн хяналт сайжирч, цахим програмын хөгжүүлэлтийг нэмэгдүүлэх		
11		Газрын хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлж, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, газар эзэмших, ашиглах эрхийн нээлттэй дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулах, Газрын биржийн үйл ажиллагааг нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах	Газрыг сонгон шалгаруулалтаар иргэдэд эзэмшүүлдэг тогтолцоонд шилжих		
12		Авлига албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах "Авлигагүй	Авлига, ёс зүйн зөрчилтэй холбоотой мэдээлэл		

		Улаанбаатар” байнгын утсыг ажиллуулах	авах арга хэлбэр сайжруулах			
13		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын мэдээллийг нээлттэй байлгах, цахим хуудсыг шинэчлэн өргөжүүлэлт шинэчлэлтийг хийх	Иргэдийн үнэн зөв, бодит мэдээлэл авах боломж, нөхцөл нэмэгдүүлэх	НЗДТГ	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2016-2019
Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд: Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх						
14	Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийх, зөрчлийг илрүүлэх, хариуцлага хүлээлгэх	Эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоо би болсон байна.	НЗДТГ, НДАА	Дүүргийн Дотоод Аудитын алба	2016-2019
15		Шилэн дансны тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хяналт тавих	Хуулийн хэрэгжилт, санхүүгийн ил тод байдал хангагдана.	НЗТТГ	НДАА, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	
16		Гадаадын зээл тусламж, орон нутгийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний явц, гүйцэтгэлийг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх	Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явц нээлттэй болж, гүйцэтгэлд тавих хяналт сайжирсан байна.	НЗДТГ, ТХАТ, НХОГ	Нийслэлийн харьяа байгууллагууд	

17	Төсвийн төслийг хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах	Нийслэлийн 2018 оны төсвийн төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх, саналыг тусгаж, НИТХ-аар хэлэлцүүлж батлуулах	Төсвийн төслийг иргэдийн оролцоотойгоор хэлэлцэж баталсан байна.	НЗДТГ	-	
Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 7 дугаар зорилтын хүрээнд: Авлигаас сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэн идэвх санаачилгыг дэмжих						
18		Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, судлаач, үнэлгээчнээр үнэлгээ хийлгэх	Төрийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн нээлттэй болж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	НЗДТГ, Ил тод Улаанбаатар Академи зөвлөлдөх ардчиллын танхим	Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага	2016-2019
19	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	Нийслэлийн Захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний чанар хүртээмжийн талаарх судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх				
20		Олон нийтийн дэд зөвлөлтэй хамтран ажиллах "Санамж бичиг" байгуулах, нээлттэй хаалганы өдөрлөгийг хамтран зохион байгуулах, олон нийтийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжруулах	НЗДТГ	Олон нийтийн дэд зөвлөл	2016-2019
21		"Ил тод Улаанбаатар Академи-Зөвлөлдөх ардчиллын танхим"-ын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, авлигын нийгмийн хор	Авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг нэмэгдүүлэх	НЗДТГ	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2016-2019

		<p>аюулыг ухуулан таниулах зорилгоор “Хүнд сурталтай төрийн үйлчилгээ- түүнээс урьдчилан сэргийлэх арга зүй” сэдэвт хэлэлцүүлгийг нийслэл, дүүргийн Иргэний танхимтай хамтран зохион байгуулах, үр дүн, зөвлөмжийг төрийн байгууллагуудад хүргүүлэх, сурталчлах</p>				
<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 11 дүгээр зорилтын хүрээнд: Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх</p>						
22		<p>Гадаад орны болон ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага солилцох</p>	<p>Хамтын ажиллагааг өргөжүүлэх</p>	НЗДТГ	<p>Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага</p>	2016-2019

Нийслэлийн Засаг даргын 2018 оны
 03 сарын 23-ны өдрийн
 А/212.9/18 захирамжийн хоёрдугаар
 хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
 ХЭРЭГЖҮҮЛЭХ 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ
 ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

№	Арга хэмжээний нэр	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт дүн /төг/	Хянасан /төг/
1	Төрийн албан хаагчдад зориулсан богино хугацааны болон давтан сургалтуудыг зохион байгуулах	4 удаа /800 албан хаагч/	Сургалтын материал- 1.500төг*800 хүн=1.200.000 төг Сургагч багш (2)-ийн хөлс- 50.000*2=100.000 төг Цайны завсарлага- 6500*800=5.200.000 төг	6500.000	
2	ЭБАТ-ыг мэдээлэл арга зүйгээр ханган ажиллах, сургах давтан сургах	2 удаа /108 хүн/	Сургалтын материал- 1500*108=162.000 төг Сургагч багш (2)-ийн хөлс- 50.000*2= 100.000 төг Цайны завсарлага- 6.500*108=702.000 төг Ур чадварын сорил 230.000 төг Тэргүүн байр-1 хүн*100.000 төг=100.000төг Дэд байр-1 хүн*80.000төг=80.000 төг Гутгаар байр-1 хүн*50.000төг=50.000төг	1194.000	
3	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалт зохион байгуулах	1 удаа	Сургалтын төлбөр-50 хүн*70.000 төг=3.500.000 төг	3500.000	
4	Авлигын эсрэг хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудас, сурталчилгаа хийх	1 удаа /3 төрлийн материал хэвлүүлэх/	Тараах материал / зурагт хуудас 3 төрөл/ 500ш* 3 төрөл =1500ширхэг*2000төг=3,000,000 төг Хууль, эрх зүйн эмхэтгэл /А6 180 хуудастай/-1500 ширхэг *1300 төг=1,950,000 төг Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв болон төрийн бусад байгууллагын үйл ажиллагааг сурталчлах	9950.000	

			нэвтрүүлэг бэлтгэх –15-20 минутын нэвтрүүлэг 5.000.000 төг		
5	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаа, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний чанар хүртээмжийн талаарх судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх	1	Баримтын судалгаа-2.250.000 Тоон судалгаа 3.000.000 Чанарын судалгаа-4.750.000 (гүнзгийрүүлсэн ярилцлага)	10.000.000	
6	"Ил тод Улаанбаатар Академи-Зөвлөлдөх ардчиллын танхим"-ын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах зорилгоор " Хүнд сурталтай төрийн үйлчилгээ-түүнээс урьдчилан сэргийлэх арга зүй" сэдэвт хэлэлцүүлгийг нийслэл, дүүргийн Иргэний танхимтай хамтран зохион байгуулах, үр дүн, зөвлөмжийг төрийн байгууллагуудад хүргүүлэх, сурталчлах	1	Телевизийн шторк хийлгэх /15-20 секунд/-1 шторк*2.356.000.=2.356.000 төг Нийслэл, дүүргийн иргэний танхимтай хамтран иргэдийн хэлэлцүүлүүлэг зохион байгуулах -26,500,000	28.856.000	
БҮГД ДҮН				60.000.000	

ТӨЛӨВЛӨГӨӨ ХҮРГҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

Улаанбаат хотын Захирагчийн ажлын алба

БАГАНУУР ДҮҮРЭГ
БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ
БАЯНГОЛ ДҮҮРЭГ
БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ
НАЛАЙХ ДҮҮРЭГ
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ
СҮХБААТАР ДҮҮРЭГ
ХАН-УУЛ ДҮҮРЭГ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗАР
АРХИВЫН ГАЗАР
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
БОЛОВСРОЛЫН ГАЗАР
ГАЗРЫН АЛБА
ГЭР ХОРООЛЛЫН ДЭД БҮТЦИЙН ГАЗАР
ДОТООД АУДИТЫН АЛБА
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН АЛБА
НИЙСЛЭЛИЙН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА
НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТЫН ЦАГДААГИЙН ГАЗАР
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР
СТАТИСТИКИЙН ГАЗАР
ТАТВАРЫН ГАЗАР
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙН ГАЗАР

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ОРДОН
ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН
АСГАТ НӨҮГ
БАГАЧУУД ХҮНС ОНӨААТҮГ
АВТО ХУДАЛДААНЫ ЦОГЦОЛБОР ОНӨААТҮГ
ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТӨВ
ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВ
НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АХМАДЫН ХОТХОН-1 ОНӨААТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭН НӨҮГ
НИЙСЛЭЛИЙН УЛААНБААТАР ЧУУЛГА
ӨСВӨР ҮЕ ХҮНС НӨҮГ

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВ
ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ
УЛААНБААТАР ЛИФТ НӨҮГ
ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ ЦОГЦОЛБОР
ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН ОНӨТҮГ
ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН, ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САН
НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС;
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС;
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС;
ГАДААД ХАРИЛЦААНЫ ХЭЛТЭС;
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС;
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХЭЛТЭС;
ЦЭРГИЙН ШТАБ.